

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Хуулийн төсөл 4 зүйлтэй байх бөгөөд хуулийг хэрэгжүүлэх цаг хугацаа болон хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж Монгол Улсын Их Хуралд тайлагнах цаг хугацааг тодорхой тусгалаа.

Өөрөөр хэлбэл, төрийн өмчит үйлдвэрийн газрыг компани хэлбэрээр өөрчлөн байгуулах, эсхүл татан буулгах асуудлыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болж, дагаж мөрдснөөс хойш 45 хоногийн дотор Засгийн газар, орон нутгийн өмчит үйлдвэрийн газрыг компани, эсхүл хуульд заасан бусад хуулийн хэлбэрээр өөрчлөн байгуулах, эсхүл татан буулгах асуудлыг Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болж, дагаж мөрдснөөс хойш 60 хоногийн дотор холбогдох хууль тогтоожмийн дагуу тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хурал шийдвэрлэхээр тусгалаа.

Түүнчлэн Хууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.3 дахь хэсэгт “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт хийх үнэлгээг тухайн хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийх бөгөөд шаардлагатай тохиолдолд дээрх хугацаанаас өмнө хийж болно.” гэж заасан тул Засгийн газар нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийж, тайланг Монгол Улсын Их Хурлын 2026 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд танилцуулах үүргийг тусгалаа.

-----oOo-----